

**УУЛ УУРХАЙН ЯАМНЫ 2014 ОНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2014.11.10

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Улсын Их Хуралд хэлэлцэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо нөхцлөөр хангах	<p>Яамны цахим хуудсаар хууль, бусад шийдвэрийн төслүүдийн талаар иргэдээс санал хүлээж авах, санал асуулга явуулах нөхцлийг бүрдүүлнэ</p> <p>Бодлогын баримт бичгүүдэд тухайн жилд хариуцан хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад орсон хууль, УИХ-ын шийдвэрийн төсөлд холбогдох яам, агентлаг иргэд, ТББ-ын саналыг тусгах,</p>	<p>Нийт 5 хуулийн төсөлд яамны цахим хуудас, дотоод сүлжээгээр болон холбогдох яам агентлаг мэргэжлийн холбоодоос санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд 3 хуулийн төслийг, 1 хуулийн төслийг БОХХАА-н байнгын хороонд хүргүүлсэн ба хуулиудын төсөлд яамдаас болон яамны цахим хуудсаар иргэдээс санал хүлээж авах, санал асуулга явуулах нөхцлийг бүрэн бүрдүүлэн ажиллаа. 2014 онд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", "Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-д өргөн барьж хэлэлцүүлэн батлуулсан байна. Шинээр гарсан хуулиудтай нийцүүлэн зарим журам дүрмийг шинээр боловсруулж Засгийн газраар батлуулах ажил яам, агентлагын түвшинд хийгдэж байна.</p> <p>УИХ-аар батлагдсан хуулиудын жагсаалт, шинээр боловсруулж байгаа журам дүрмийн жагсаалтыг хавсаргав.</p> <p>Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулан яамны цахим хуудсанд байршуулан холбогдох яам агентлаг, мэргэжлийн холбоодоос санал авч Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр</p>

			Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Жагсаалтыг хавсаргав.
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх	Ажилтнуудын дунд яриа танилцуулга, мэдээлэл хийх, хэвлэмэл хуудас, гарын авлага материал тараах, цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах	<p>Яамны албан хаагчдын дунд хаагчдад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар сургалт явуулсан. Сургалтыг АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ажилтан комиссар Н.Мөнхбаяр явуулж, гарын авлага материал өгсөн. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, семинарт яамны ЭБАТ болон яамны албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Сургалт семинарийн үеэр өгсөн гарын авлага материалыг яамны удирдлагуудад танилцуулж өгсөн.</p> <p>Уул уурхайн яамны үйл ажиллаганы стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр баталсан Засгийн газрын 2014 оны 261 дүгээр тогтоол, “Шагналын журам батлах тухай” Уул уурхайн сайдын 2012 оны 28 дугаар тушаалд өөрчлөлт оруулж Уул уурхайн сайдын 2014 оны 83 дугаар тушаал, “Яамны зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 136 дугаар тушаалыг яамны цахим хуудас болон E-оффис, яамны үүдний заалан дахь цахим самбар болон яамны мэдээллийн самбарт байрлуулсан байна. Мөн дээрх эрх зүйн актууд болон яамны хөдөлмөрийн дотоод журам, сургалтын журам, “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр” “Орон сууц, түүнд</p>

			<p>зориулсан хөрөнгийг хуваарилах журам"-ыг яамны дотоод сүлжээ болон E-office-д байршуулсан. "Авлигын эсрэг хууль", Авлигын эсрэг хуулинд орсон нэмэлт оруулах тухай хууль" болон "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам", АТГ-ын цахим бүртгэлийн программ болон бусад хууль тогтоомжуудыг байршуулсан. АТГ-ын</p>
		<p>Яамны албан хаагчдын дунд "Авлигын эсрэг хамтдаа" уриалга гарган ажиллах</p>	<p>"Авлигын эсрэг хамтдаа" самбарыг яаманд ажиллуулж "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам", бусад хууль тогтоомжууд болон сурталчилгааны бусад гарын авлаг материалыг байршуулан "Авлигын эсрэг хамтдаа" уриатай ажиллаж байна.</p>
		<p>Авлагатай тэмцэх газраас ирүүлсэн сурталчилгааны материалыг харьяа байгууллагууд болон албан хаагчдад түгээх сурталчлах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 100 асуулт, "Нийтийн албан тушаалтан танд хуулиар юуг зөвшөөрч юу хориглох вэ" гэсэн сурталчилгааны гарын авлага болон бусад материалыг яамны удирдлагууд, албан хаагчид болон Уул уурхайн аврах албаны албан хаагчдад түгээж сурталчилсан. Яаманд зохион байгуулсан</p>

			сургалтад Уул уурхайн аврах албаны ХАСХОМ-ээ гаргаж өгөх албан хаагчид болон эрх бүхий албан тушаалтныг хамруулсан байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Сургалт семинарийн үеэр өгсөн гарын авлага материалыг яамны удирдлагуудад танилцуулж өгсөн.
3	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй санал солилцох	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг яамны цахим хуудас болон E-оффис , мэдээллийн самбарт байрлуулна.	Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг яамны цахим хуудас болон E-оффис, мэдээллийн самбарт тогтмол байрлуулж байна.
		Бодлогын баримт бичгийн болон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим самбар, саналыг хайрцаг, утас, мөн угтах үйлчилгээний ажилтанг шинээр томилон ажиллуулж байна. Утас 264373. Тайлан хавсаргав.
4	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	Дотоод хяналтын асуудлыг албан тушаалтанд хариуцуулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	Яамны дотоод хяналтын асуудлын ажлыг чиг үүргийн дагуу ХШҮДАГ хариуцан яамны 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний дагуу дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж Төрийн нарийн бичгийн даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгч байна. ХҮШҮДАГ-аас хийсэн хяналт, шалгалт, үнэлгээний тайлангуудыг хавсаргав.
		Хяналт шалгалтын ажлын тайлан мэдээг яамны цахим хуудас болон мэдээллийн самбараар олон нийтэд ил тод мэдээллэнэ.	Хяналт шалгалтын ажлын тайлан мэдээг яамны цахим хуудас болон мэдээллийн самбараар олон нийтэд ил тод мэдээлж байна. Хяналт шалгалтын тайланг хавсаргав.
5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалтыг олон	2014 оны төсөв, 2013 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны жилийн төсвийн төслийг олон нийтэд тухай бүр мэдээллэж байх	Төсвийн төслийг боловсруулахдаа үйл ажиллагааны зорилго зорилттой нягт уялдуулан яамны харъяа байгууллагуудаас саналуудыг авч нэгтгэн ажиллаж байна. Мөн салбарын Төрийн өмчит байгууллагууд,

	<p>нийтэд тухай бүр мэдээллэх</p>		<p>төрийн бус байгуулагуудтай нээлттэй хэлэлцүүлэг хийж тэдний саналыг тусган ажиллаж байна. Байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар олон нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулж байна. Яамны цахим хуудсанд төсөв санхүүгийн ил тод байдал гэсэн цэс нээж төсвийн гүйцэтгэлийн тайлан, хөрөнгө оруулалтын тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг ил тод тогтмол байршуулж байна.</p>
		<p>Жилийн эцсийн санхүүгийн тайлан яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээллэнэ.</p>	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайлан балансыг яамны сайтад байршуулан ажиллаж байна.</p>
		<p>Яамны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна.</p>	<p>Сайдын багцын 2013 оны аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь яамны сайт болон мэдээллийн самбарт байршуулсан байна.</p>
<p>6</p>	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p>	<p>Яам, агентлагаас олгож байгаа зөвшөөрөл / тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт , түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг яам, агентлагын цахим хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг ил тод нээлттэй байдлыг хангана.</p>	<p>Яам, агентлагаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн жагсаалт түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг яам, АМГ, ГТГ-ын цахим хуудсанд байршуулж, яамны угтах үйлчилгээгээр дамжуулан иргэдэд гарын авлага материалыг тарааж зөвлөгөө өгч санал хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна. Мөн АМГ-аас олгож байгаа тусгай зөвшөөрөл, лицензийг өдөр тутмын сонингуудаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээллэж байна. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013.05.07-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлуулан хэрэгжүүлж байна. 2014 онд олгосон тусгай зөвшөөрлийн жагсаалт тайлангуудыг хавсаргав.</p>

		Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг яамны цахим хуудсанд байрлуулна.	Өмнө олгосон болон Уул уурхайн яам байгуулагдсанаас хойш олгосон Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг яамны цахим хуудсанд байрлуулсан.
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	Сул ажлын байранд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулна.	Уул уурхайн яам болон харьяа агентлагуудын удирдах албан тушаалын сул ажлын байранд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1; 35 дугаар зүйлийн 35.1.6, болон “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг үндэслэн яамны дэргэдэх ТАСЗ-өөс сонгон шалгаруулалт зарлан ТЗУГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулан 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу дараах ажлын байранд сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулсан. Үүнд: Уул уурхайн яам: Түлшний бодлогын хэлтсийн дарга ТЗУГ-ын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ашигт малтмалын газар: Региональ судалгааны тасгийн дарга Уул уурхайн хэлтсийн Технологи, үйлдвэрлэлийн тасгийн дарга Бичил уурхайн тасгийн дарга Сонгон шалгаруулалтад тэнцсэн албан хаагчийг Төрийн албаны салбар зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн нэр дэвшүүлж тогтоол гарган тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд санал болгож томилсон.
		Уул уурхайн яамны хүний нөөцийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан батлуулж , хэрэгжилтийг хянаж, үнэлэх	Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 89 дүгээр тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулсан Уул уурхайн яамны хүний нөөцийн хөтөлбөрийг шинээр

	<p>журмыг цахим хуудсанд байршуулна.</p>	<p>боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Ажлын хэсгийн ахлагчаар батлуулан ажиллаж байна. Тушаал ажлын хэсгийн төлөвлөгөө, төслийг хавсаргав.</p>
	<p>АМГ-ын тасгийн дарга нарын сонгон шалгаруулалтыг хийж нэр дэвшүүлэх</p>	<p>Салбар зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар Региналь судалгааны тасгийн даргад Д.Оюунцэцэг, Уул уурхайн хэлтсийн Технологи, үйлдвэрлэлийн тасгийн даргад Б.Элбэгзаяа, Бичил уурхайн тасгийн даргад Д.Сагараадорж нарын нэрийг дэвшүүлж Ашигт малтмалын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж байна. Тогтоол, тушаалын хуулбарыг хавсаргав.</p>
	<p>Яамны албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх заавар боловсруулан хэрэгжүүлнэ.</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны тушаалаар батлагдсан "Албан хаагчдын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн яамны төсвийн шууд захирагч болон нэгжийн менежерүүд, төрийн жинхэнэ албан хаагчидтай 2014 оны үр дүнгийн гэрээ байгуулан эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэсэн.</p> <p>2013 оны жилийн эцсийн байдлаар Уул уурхайн яамны 53 төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулан үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэснээс маш сайн буюу "А" үнэлгээтэй 33, сайн буюу "В" үнэлгээтэй 19, хангалттай буюу "С" үнэлгээтэй 1 пүгнэгдсэн бол 2014 оны эхний хагас жилийн байдлаар 52 албан хаагч А үнэлгээтэй, 14 албан хаагч В үнэлгээтэй дүгнэгдсэн байна.</p>
	<p>Төрийн албан хаагчдад дараах сэдвээр сургалт явуулна.</p>	<p>Төрийн албан хаагчид болон шинээр ажилд томилогдсон албаг хаагчпап зориулан тусгай</p>

		<p>Төрийн албан хаагчдад дараах сэдвээр сургалт явуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Архив бичиг хэрэг, баримт бичиг боловсруулах аргачлал - Хууль, тогтоол, шийдвэр боловсруулах аргачлал - Монгол бичгийн зөв бичих дүрмийн шинэчлэлийн талаар -Байгууллагын соёл, төрийн албан хаагчийн харилцааны соёл -Төрийн албан хаагчийн ёс зүй 	<p>хөтөлбөрийн дагуу ажлын байран дахь сургалтыг зүхиүн байгуулж байна. Сургалтын хөтөлбөр, ирцийг хавсаргав.</p>
8	<p>Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэглэлээр нийтэд зарлана.</p>	<p>Уул уурхайн яам болон Сангийн яамны цахим хуудсанд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нээлттэйгээр байршуулж байна. Төлөвлөгөөг хавсаргав.</p>
		<p>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна.</p>	<p>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг Сангийн яамны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулж байгаагаас гадна тендерийн урилгыг өдөр тутмын сонингуудад ил тод нээлттэй мэдээллэж байна. Холбогдох материалыг хавсаргав.</p>
9	<p>Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох</p>	<p>Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын чиг үүрийг тодорхой болгож шинээр бий болсон ажлын байрны тодорхойлолтыг холбогдох журмын дагуу боловсруулан ТНБД-ын тушаалаар баталж мөрдүүлнэ.</p>	<p>Уул уурхайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолоор баталсан. Яамны зохион байгуулалтын нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 64 дүгээр тушаалаар батлан мөрдөж байна. 2014 онд Яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг тодорхой болгох, давхацлыг арилгах, Шинэчлэлийн засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах, орон тоо бүтцийг боловсронгуй болгох зорилготой</p>

			<p>ажлын хэсгийг ТНБД-ын тушаалаар байгуулан ажиллуулж ажлын хэсгийн дүгнэлтийг сайд Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан улмаар Засгийн газрын хуралдаанд Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан оруулж хэлэлцүүлэн Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 261 дүгээр тогтоол гарсан. Уг тогтоолоор яамны орон бүтцэд өөрчлөлт оруулан 5 газар, 5 хэлтэс, 73 орон тоотой байхаар баталсан. Түлшний бодлогын хэлтэс Түшний бодлогын газар болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын чиг үүрийг тодорхой болгож, шинээр бий болсон ажлын байрны тодорхойлолтыг холбогдох журмын дагуу боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 136 дугаар тушаалын дагуу батлан мөрдөж байна.</p>
		<p>Албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангана.</p>	<p>Яамны албан хаагчдын хариуцсан ажил үүргийг чиглэл, газар, хэлтсийн үйл ажиллагааны стратегийг яамны цахим хуудас болон цахим самбарт байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p>
<p>1 0</p>	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах</p>	<p>Салбарын хэмжээнд авлигатай тэмцэх талаар төрийн бус байгууллагууд иргэдтэй хамтран уулзалт, ярилцлага зохион байгуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн "Мэдээллийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай" 01/2797 тоот албан бичгийн дагуу "Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, хэлэлцүүлэгт Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Авлигатай тэмцэх газар, аймаг сумд, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцлоо.</p>

		Салбарын хэмжээнд авлигаас урьчилан сэргийлэх талаар судалгаа авах дүгнэлт гаргах ажлыг нийгмийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.	"Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулах үеэр хэлэлцүүлэгт оролцогчдоос санал, хүсэлтийг нь саналын хуудсаар авч нэгтгэж байна. Санал хүсэлтийг нь хавсаргав.
1 1	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтан ажиллуулна.	Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тодорхой тусгах	Монгол Улсын Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх хэсэг, Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргээлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЭБАТ-наар ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн Ж.Дэмчигсүрэнг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс томилон Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах талаар Ажлын байрны тодорхойлолтод нь тусган ажиллаж байна. Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 91 дүгээр тушаалын 1, 2 дугаар хавсралтын дагуу 2014 онд нийтийн албанд нэр дэвшсэн 16 этгээдээс "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг, 11 албан хаагчаас Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэлийг тухай бүр цаасаар болон цахимаар хөтөлж байна. Мөн 2014 онд 80 албан

			<p>хаагчаас "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ийг гаргуулан, гарын үсэг зуруулж баталгаажуулан, цахим програм дахь холбогдох мэдээллийг тогтмол шинэчилж бүртгэж байна.</p> <p>Мэдүүлэг гаргагчийн шилжилт хөдөлгөөнийг мэдүүлгийн цахим програмд тогтмол шинэчлэн бүртгэж байна.</p>
		Авлигтай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтад тасралтгүй хамрагдах	Авлигтай тэмцэх газраас зохион байгуулж байгаа бүх сургалтад тасралтгүй оролцож байгаа.
		Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг хадгалалт хамгаалтыг бүрэн хангана.	Албан хаагчдын ХАСХОМ-ийг нууцийн тэмдэг дарсан дугтуйнд хийж цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаалт гарган сейфэнд журмын дагуу хадгалж байна. Лац тэмдэгтэй болно. ЭБАТ нь нууцын баталгаа гаргуулсан болно.
		Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнг үнэлэх аргачлалыг боловсруулан хэрэгжүүлнэ.	Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнг нь үнэлэх талаар төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээнд тодорхой тусган хагас бүтэн жилээр дүгнэж байна.
1 2	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон хэрэгжүүлнэ.	Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газрын саналыг тусган боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулна.	Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 136 дугаар тушаалаар Уул уурхайн яамны ажилтан албан хаагчдын ёс дүрмийг батлан мөрдөж байна. Журмыг хавсаргав. Журмын төслийг АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Ж.Сарангэрэлд хүргүүлж санал авсан болно.
		Ёс зүйн дүрмийг батлуулж төрийн албан хаагчдад танилцуулан мөрдүүлнэ.	Яамны дэргэд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хянах Ёс зүйн хороог Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ахлуулан 8 хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж ТАЗ-ийн салбар зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн

			01 дугаар тогтоолоор байгуулан ажиллуулж байна. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 136 дугаар тушаалаар Уул уурхайн яамны ажилтан албан хаагчдын ёс дүрмийг батлан мөрдөж байна.
		Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлнэ. Бүртгэл хөтөлж хэрэгжилтийн талаар хамт олонд тогтмол мэдээллэнэ.	Зөрчлийг ЭБАТ бүртгэж авах бөгөөд одоогоор бүртгэгдсэн зөрчил байхгүй болно.
1 3	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулан мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулна.	Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6-д заасны дагуу мэргэжлийн зөвлөгөө өгөх, байгууллагын удирдлагын зөвшөөрснөөр багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх боломжтой бөгөөд энэ дагуу яамны Геологийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Алтанхуяг ШУТИС-ын Геологи, уул уурхай, газрын тосны сургуульд цагийн багш хийдэг бөгөөд өөр давхар ажил эрхэлдэг албан хаагч байхгүй болно. Төрийн албаны тухай хуулийг яамны цахим хуудсанд байршуулсан болно.
1 4	Яамны удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	Уул уурхайн сайд, Уул уурхайн яамны ТНБД яамны удирдлагуудаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлууна.	Уул уурхайн сайд болон болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан журам дүрмийг яамны цахим хуудас болон мэдээллийн цахим самбарт тогтмол тавьж байна.
		Уул уурхайн сайд, Уул уурхайн яамны ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал/-ыг ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим	Уул уурхайн сайд, Уул уурхайн яамны ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал/-ыг ил тод, нээлттэй байдлыг хангаж яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлуулж байгаа.

		хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байрлуулна.	
		Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх журам дүрэм, зааварын ил тод нээлттэй байдлыг хангана.	Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх дүрэм, журмуудыг яамны цахим хуудсанд байршуулан товхимол болгон хэвлэн угтах үйлчилгээн дээр байрлуулан иргэдийг мэдээллээр хангаж байна. Мөн АМГ-аас сар бүр гаргаж байгаа статистик мэдээллийг байршуулж байна.
1 5	Иргэдийн өргөдөл/санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн мэдээллийг хүлээн авч шалгах	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх хүрээний асуудлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэж сурталчилна.	Уул уурхайн яам нь сар бүрийн 25-ны өдөр “Ил тод уул уурхай” хэвлэлийн бага хурлыг тогтмол зохион байгуулж, геологи уул уурхай, газрын тосны салбарт хийж хэрэгжүүлсэн ажлаа олон нийтэд тогтмол мэдээллэж байна. Түүнчлэн улирал бүр Монгол Улсад суугаа дилломат төлөөлөгчийн газрынханд салбарынхаа мэдээллийг хүргэж байгаа болно. Өнгөрсөн хугацаанд Европын холбооны улсаас Монгол Улсад суугаа 25 улсын Элчин сайдтай уулзалтыг 2 удаа зохион байгуулсан. Мөн салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийх 2 талын болон олон талт уулзалтыг идэвхжүүлж тэдний санал бодлыг сонсч, яамны бодлого, үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. Уул уурхайн сайдын тушаалаар яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого, зорилт хийгдэж буй ажлын үр дүн өгөөжийн талаар олон нийтэд хүртээмжтэй ил тод хүргэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх Ажлын хэсэг байгуулсан. Энэхүү ажлын хэсэг нь яамны олон нийттэй харилцах төлөвлөгөөг гарган хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран

		ажиллаж байна. Уул уурхайн яам нь өдөр тутмын сонин, телевиз, сайтаар өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол түгээж байна.
	Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж утас, санал авах хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс ажиллуулна.	Өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх , төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013.05.07-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлуулан хэрэгжүүлж байна. Угтах үйлчилгээний ажилтныг томилон саналын хайрцаг, утас ажиллуулж байна. Мөн 1111 төвөөр дамжуулан иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байна.
	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулсан байдал	Яамны албан хаагчдын хариуцсан асуудал, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, харилцах утас, ажлын байрны чиг үүргийг үүдний зааалны хананд цахим салбарт тусгай цэс нээж байршуулсан. Яаманд өөрийн биеэр ирсэн болон угтах үйлчилгээний 264373 дугаарын шуурхай утсанд холбогдсон иргэд, байгууллагад Уул уурхайн яамны үйл ажиллагаатай холбоотой болон бусад холбогдох мэдээллийг шуурхай өгч, шаардлагатай тохиолдолд цааш нь холбож өгч ажиллаж байна. 2014 оны эхний 11 сарын байдлаар 391 дуудлага хүлээн авч ажиллаа. 2014 оны эхний 11 сарын байдлаар нийт 17,125 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөгчид Уул уурхай, эрчим хүчний яамны байранд бүртгэгдэн орсон байна.
	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээллэсэн байдал	2014 онд иргэдээс албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл: Уул уурхайн яаманд нийт 419 өргөдөл, санал, гомдол ирснээс шийдвэрлэж хариу өгсөн 370, бусад байгууллагат

			<p>шилжүүлсэн 30, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 10, хугацаа болоогүй 9 шийдвэрлэлт 96.3 хувьтай байна. 2014 онд дээд газар, УИХ-ын гишүүдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт: Ерөнхийлөгчийн тамгын газраас 21, УИХ-аас 1, УИХ-ын гишүүнээс 13, ЗГХЭГ-аас 44, ХЗЯ-наас 1, нийт 80 өргөдөл гомдол ирснийг 100% хугацаанд нь шийдвэрлэсэн байна.</p> <p>2014 онд иргэдээс Төрийн захиргааны төв байгууллагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн хувьд Уул уурхайн яаманд 10842 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 1111 төвөөр 1465, утсаар 223, биечлэн уулзаж шийдвэрлэсэн 8803 байна. Хийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 36.7% нь ажилд орох, гарах, чөлөө хүсэх, томилуулахтай холбогдсон хүсэлт, 21% нь геологи, уул уурхай, металл, газрын тосны салбартай холбогдсон, 8% нь тусгай зөвшөөрөлтэй холбоотой, 34% нь бусад асуудлаар ирсэн байна.</p>
1 6	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтийг гаргана.	Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалын судалгааг гаргасан судалгааг хавсаргав.
		Эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргуулан бүртгэж байна. Энэ талаар албан хаагчдад зөвлөмж мэдээллийг Е-оффис болон мэдээллийн самбарт тавьж мэдээллэж байна. Холбогдох материалыг хавсаргав.
		Авлигын эсрэг ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг	УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Албантушаалтны хувийн ашигсонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-

		сонирхолын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулна.	ын дагуу “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийт 80 албан хаагчаас цахимаар болон цаасаар гаргуулан хянаж бүртгэж, 2013 оны тайлан мэдээг хугацаанд нь АТГ-т хүргүүлсэн. “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 19 этгээдээс гаргуулан авч бүртгэн холбогдох материалын хамт АТГ-т хүргүүлэн хянуулж шийдвэрлүүлсэн. “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 11 албан хаагчаас гаргуулан хянаж бүртгэсэн байна. Шинэ хуулийн дагуу 2 албан хаагч их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн байна. 2014 онд Уул уурхайн яаманд АМГ-аас 4 албан хаагч, ГТГ-аас 1 албан хаагч, УИХ-ын Тамгын газраас 1 албан хаагч, Уул уурхайн яамнаас 1 албан хаагчийг АМГ-т Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн дагуу сэлгүүлэн ажиллуулсан.
1 7	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж биелэлтийг хугацаанд АТГ-т хүргүүлнэ.	Авлигатай тэмцэх газраас 2014 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 03/7007 албан тоотоор ирүүлсэн “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” зөвлөмжийн хэрэгжилтийг гарган Төрийн нарийн бичгийн даргын албан тоотоор АТГ-т хүргүүлсэн болно.
1 8	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, хүчин чармайлт	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриалгыг дэмжиж ажиллана	Салбарын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. Уул уурхайн сайдын 2013.09.27-ны өдрийн 201 дүгээр тушаалын байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Уул уурхайн үндэсний ассоциаци болон Нүүрс ассоциаци, ГУУҮЭ-ийн холбооны төлөөлөл оролцож салбарын хамтын хэлэлцээрийн хэрэгжилтэд шалгалт хийх явцад “Шивээ-Овоо” ХК, “Алтайн хүдэр” ХХК, “Алтан дорнод” компаниудын удирдлагатай уулзахдаа Авлигаас урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хамтдаа тэмцэх талаар санал солилцсон. Ажлын

			хэсгийн тайланг боловсруулан Уул уурхайн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон газар хэлтсийн дарга нарт танилцуулсан.
1 9	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлагазохион байгуулах харьяа байгууллагуудад зөвлөмж өгөх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулна	Яамны албан хаагчдад “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүй, Харилцааны соёлын асуудлаар шинээр албан тушаалд томилогдсон албан хаагчдад сургалт явуулсан. Мөн АМГ болон ГТГ-ын ЭБАТ-нуудад ажил төрлийн талаар зөвлөгөө өгч мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж байна. Уул уурхайн сайдын 2013.06.13-ны өдрийн 132 дугаар тушаалаар байгуулагдсан АМГ-ын үйл ажиллагаанд шалгалт хийх ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтэд шалгалт хийж ХАСХОМ-ийг бүртгэх хадгалах, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх талаар зохион байгуулах ажлын талаар зөвлөгөө өгсөн. Тушаалын хуулбарыг хавсаргав.
2 0	Орон нутгийн захиргааны байгууллага, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл зээмшигч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах үйл явцад тавих хяналтыг сайжруулах	Уул уурхайтай аймаг, сумдын судалгаа гаргах Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлж, Нийгмийн хариуцлагын гэрээг хуульд нийцүүлэн байгуулах асуудлаар Уул уурхайн сайдын албан тоот, зөвлөмжийг аймаг, сумдуудад хүргүүлэх	Уул уурхайтай аймаг, сумдын судалгааг гаргасан. Судалгааг хавсаргав. Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн "Мэдээллийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай" 01/2797 тоот албан бичгийн дагуу Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлж, Нийгмийн хариуцлагын гэрээг хуульд нийцүүлэн байгуулах асуудлаар "Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай" Уул уурхайн сайдын

			2014 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 1/1156 тоот албан бичгийг аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн.
		Алтны уурхайтай сумдуудын удирдлагуудтай нийгмийн хариуцлагын гэрээний асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах	"Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулж, хэлэлцүүлэгт Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Авлигатай тэмцэх газар, аймаг сумд, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл оролцлоо. Хэлэлцүүлгийн хөтөлбөр болон холбогдох мэдээллийг хавсаргав. 2014 оны 11 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод "Орон нутгийг хөгжүүлэх гэрээ" сургалтыг Уул уурхай, эрчим хүчний яам, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Тогтвортой хөгжил /SDS/ компани, ISLP, SDSG-тэй хамтарн зохион байгуулсан. Сургалтын таэриалыг хавсаргав.
		Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад аж ахуйн нэгж, орон нутгийн захиргааны байгууллага хооронд хамтран ажиллах эрх зүйн харилцааг тодорхой болгон тусгах, нийгмийн хариуцлагын гэрээний загварыг шинээр батлуулах	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу "Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний төслийг Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар хамтран боловсруулж байна. Төслийг хэлэлцүүлгийн үеэр танилцуулж санал авсан болно.
2 1	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОУИТБС/-ыг хэрэгжүүлэгч улс орнуудад тавигдах шаардлагын хүрээнд олон нийтэд нээлттэй кадастр, лицензийн бүртгэлийн мэдээллийн сантай байх энэхүү санд ОУИТБС-ын тайланд хамрагдсан бүх	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ил тод байдлын тайланг гаргаж байгаа аж ахуйн нэгжийн тооны хувьд 2006 оны 64 аж ахуйн нэгж гаргаж байсан бол 2007 онд 102 аж ахуйн нэгж, 2008 онд 115 аж ахуйн нэгж, 2009 онд 129 аж ахуйн нэгж, 2010 онд 274 аж ахуйн нэгж, 2011 онд 301 аж ахуйн нэгж, 2012 онд нийт 1531 аж ахуйн нэгж, 2013

		<p>компанийн эзэмшиж буй лиценз болгоны мэдээллийг оруулах</p>	<p>онд 1197 аж ахуйн нэгж гаргаж жил ирэх тусам хамрах хүрээ нь өргөжин тэлсээр байна.</p> <p>Мөн Засгийн газрын хувьд улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан орлого буюу 2006 оны ОҮИТБС-ын тайланг 134 аж ахуйн нэгжийн хүрээнд гаргаж байсан бол 2007, 2008 онд 184 аж ахуйн нэгжийн хүрээнд, 2009 онд 363 аж ахуйн нэгжийн хүрээнд, 2010 онд 477 аж ахуйн нэгжийн хүрээнд, 2011 онд 518 аж ахуйн нэгжийн хүрээнд, 2012 онд 1829 аж ахуйн нэгжийн хүрээнд, 2013 онд 1617 аж ахуйн нэгжийн хүрээнд тус тус гаргаж, тайлангийн хамрах хүрээ жил бүр нэмэгдэж байна.</p> <p>Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 8 удаагийн нэгдсэн тайлан гаргаад байна. Гэвч зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, төрийн захиргааны байгууллага тайлан гаргах ажилд хойрго хандах, олон дахин шаардуулах, тайлангийн мэдээ тоо баримт зөрөх, эдгээр зөрүүтэй байдлыг нэгдсэн тайлан гаргах үед эргэж тодруулахад хойрго хандах зэрэг дутагдал жил жилд давтагдан гарч байна. Энэ нь энэхүү ОҮИТБ-ын санаачилгыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох практик үндэслэл болж байна.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуулиар ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна” хэмээн зааж Ашигт малтмалын тухай хуулийн үйлчлэх хүрээг хязгаарласан байх тул эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг нийтлэг зохицуулалт бүхий бие даасан хуулиар зохицуулах нь оновчтой зохицуулалт болох юм. Өөрөөр хэлбэл, эрдэс</p>
--	--	--	---

			<p>баялгийн салбарын үйл ажиллагааг олон тооны салбар хуулиудаар зохицуулж байгаа, цаашид ч нарийвчилсан харилцаа бүхий хуулиуд батлагдах тул ил тод байдлын зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзсэн болно.Хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж улмаар УИХ-д өргөн мэдүүлээд байна.</p> <p>Энэхүү хуулийн төслөөр эрдэс баялгийн салбарын ил тод байдлын зорилт, хамрах хүрээ, зарчим, эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэгч байгууллага түүний бүтэц, бүрэн эрх, мөн эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, тэдгээрийн эрх үүрэг түүнчлэн эрдэс баялгийн ил тод байдлын тайлан түүнтэй холбоотой харилцаа, тайлан гаргах үүрэг бүхий хуулийн этгээд, байгууллагууд, тэдгээрийн эрх үүрэг, эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын санхүүжилт, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага гэх харилцааг зохицуулсан.</p> <p>Хуулийн төсөл болон холбогдох материалыг хавсаргав.</p>
		<p>Олборлох салбарын тендерт оролцон, хөрөнгө оруулалт хийн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг корпораци аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай, тэдний эзэмшлийн хувь хэмжээний мэдээллийг нээлттэй болгох</p>	<p>Олборлох салбарын тендерт оролцон, хөрөнгө оруулалт хийн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг корпораци аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тухай, тэдний эзэмшлийн хувь хэмжээний мэдээллийг нээлттэй болгох асуудлыг Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгасан.</p>
		<p>Ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохоор хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцөлийн</p>	<p>Ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохоор хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг нээлттэй болгох асуудлыг Эрдэс</p>

		талаарх мэдээллийг нээлттэй болгох	баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгасан.
		Олборлох салбараас хүлээн авсан орлого болон ашигт малтмал, газрын тос байгалийн хий олборлож буй компаниас төрд төлсөн төлбөрийг ил тод нээлттэй мэдээлэх, мөн төлбөр төлж буй компани нь эдгээр төлбөрийн талаарх мэдээллийг ил болгох	Олборлох салбараас хүлээн авсан орлого болон ашигт малтмал, газрын тос байгалийн хий олборлож буй компаниас төрд төлсөн төлбөрийг ил тод нээлттэй мэдээлэх, мөн төлбөр төлж буй компани нь эдгээр төлбөрийн талаарх мэдээллийг ил болгох асуудлыг Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд тусгасан.

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭЖ ГАРГАСАН: ТЗУГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
Ж.ДЭМЧИГСҮРЭН